



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 409

Улаанбаатар хот

### Хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 6 нэрийн, нийт 76,106,575.25 (далан зургаан сая нэг зуун зургаан мянга таван зуун далан таван төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Галбадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ  
132007625

Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2021 оны 12  
дугаар сарын 30-ны өдрийн  
729 дугаар тогтоолын хавсралт

**"Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд  
бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн жагсаалт**

| № | Автомашины марк, улсын<br>дугаар, зориулалт, хөдөлгүүр,<br>арлын дугаар                                         | Үйлдвэр<br>лэсэн он | Балансын үнэ,<br>Хуримтлагдсан<br>элэгдэл /төгрөг/                                                                                  | Худалдах доод<br>үнэ /төгрөг/        |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------|
| 1 | Донгфенг маркийн, 68-40 ХӨҮ<br>улсын дугаартай ачааны<br>автомашин, арлын дугаар-<br>LGDTK81G39A159796          | 2009/2010           | 11,151,191.00                                                                                                                       | 1,000,000.00                         |
| 2 | Мицубуши Л-200 маркын , 41-25<br>ХӨҮ улсын дугаартай, суудлын<br>автомашин арлын дугаар-<br>MMBJNK74010015574   | 2001/2001           | 2,225,000.00                                                                                                                        | 2,000,000.00                         |
| 3 | Ниссан Экстриал маркийн, 81-<br>39 ХӨҮ улсын дугаартай,<br>суудлын автомашин, арлын<br>дугаар-NT30026617        | 2001/2008           | 16,628,000.00                                                                                                                       | 2,000,000.00                         |
| 4 | Тоёота гранд марк-2 маркийн,<br>81-28 ХӨҮ улсын дугаартай,<br>суудлын автомашин, арлын<br>дугаар- JZX1106052898 | 2003/2011           | 15,000,000.00                                                                                                                       | 1,500,000.00                         |
| 5 | УАЗ фермер маркийн, 41-26<br>ХӨҮ улсын дугаартай, ачааны<br>автомашин, арлын дугаар-<br>ООО103160471228         | 2006/2006           | 2,220,000.00                                                                                                                        | 1,000,000.00                         |
| 6 | Ловол Потон маркийн трактор,<br>арлын дугаар-TD037527N                                                          | 2007/2007           | 28,882,384.25                                                                                                                       | 500,000.00                           |
|   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                                                                       |                     | <b>76,106,575.25 (далан<br/>зургаан сая нэг зуун<br/>зургаан мянга таван<br/>зуун далан таван<br/>төгрөг хорин таван<br/>мөнгө)</b> | <b>8,000,000.00<br/>(найман сая)</b> |